

# Эд хөрөнгө асуулт

**Асуулт:** Миний нэр дээр газар өмчлөх шийдвэр гараад Газрын албанаас автал улсын бүртгэлийн байгууллагад очоорой гэсэн. Би хаана хандаж, ямар баримт бүрдүүлж өгөх вэ?

**Хариулт:** Та доорх баримт бичгийг бүрдүүлэн харьяа Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хандана. Үүнд: – Мэдүүлэг /Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хүлээн авах цонхноос авна/ – Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай шийдвэр ийн эх хувь, – Газрын кадастрын зураг /эх хувь/, – Газрын төлөв байдал, хянан баталгааны дүгнэлтийн хуулбар зэргийг бүрдүүлж өгнө. Үнэ төлбөргүй бөгөөд ажлын 5 өдрийн дотор эрхийн улсын бүртгэлд бүртгэх эсэхийг шийдвэрлэж мэдэгдэнэ. /Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйл/

**Асуулт:** Би өөрийнхөө нэр дээр эд хөрөнгө байгаа эсэх лавлагааг авах гэсэн юм. Хэд хоноод гарах вэ? Хаана хандах вэ?

**Хариулт:** Та цахим үнэмлэх болон хурууны хээгээ ашиглан Төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машинаас 1000 төгрөгөөр шууд авах боломжтой. Хэрвээ иргэний цахим үнэмлэх гэмтэлтэй ч юм уу, хурууны хээ уншигдахгүй алдаа гарч байвал, мөн хуулийн этгээд болон итгэмжлэлээр лавлагаа авах гэж байгаа бол Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст доорх баримт бичгийг бүрдүүлэн хандаж болно. Үүнд: – Мэдүүлэг /бүртгэлийн байгууллагын хүлээн авах цонхноос авна/ – Үйлчилгээний хураамж энгийн бол 5 000 төгрөг /ажлын 5 хоногт/, яаралтай бол 10 000 төгрөг /ажлын 8 цагт/ тушаасан баримтын хамт өгнө. /ЗГ-ын 2010 оны 237 тогтоол/

**Асуулт:** Үл хөдлөх, газрын гэрчилгээ шинээр авахад Улсын бүртгэлд өргөдөл гаргана гэх юм. Өргөдөл нь ямар загвартай байдаг вэ?

**Хариулт:** Жишээ

## СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ ӨРГӨДӨЛ ГАРГАХ НЬ

/газар/

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 5-р багийн иргэн Болд овогтой Батаа миний бие нь аймгийн засаг даргын 2017.10.9 өдрийн А/01 тоот захирамжаар Баруун-Урт сумын 5-р баг Дэнжийн 9-10 тоот хаягт байрлах 700 м<sup>2</sup> талбайтай газрыг өмчлөн авсан юм.

Иймд Улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгож өгнө үү.

Өргөдөл гаргасан 5-р багийн иргэн Б.Батаа

## СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ ӨРГӨДӨЛ ГАРГАХ НЬ

*/үл хөдлөх/*

Болд овогтой Батаа /2 өмчлөгчтэй бол нэрийг нь оруулна/ миний бие нь Баруун-Урт сумын 5-р баг Дэнжийн 9-10 тоот хаягт байрлах 700 м2 талбайтай газар дээрээ 5\*7 харьцаатай 35 м2 талбайтай хувийн сууцыг палк модоор барьж гадуур нь тоосгоор өнгөлсөн, 3 вакум цонхтой төмөр дээвэртэй 3 өрөө хувийн сууцыг 2017 онд барьж ашиглалтанд оруулсан.

Уг хувийн сууц нь 35 сая төгрөгийн үнэлгээтэй болно. Иймд Улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгож өгнө үү

Өргөдөл гаргасан 5-р багийн иргэн Б.Батаа

Асуулт: Шинээр барьсан хувийн эзэмшлийн байшингийн гадна талын зургийг хэрхэн авах вэ?

Хариулт: Жишээ

### *Бат овогтой Доржын эзэмшлийн барилгын зураг*



*Баруун тал*



*Урд тал*




*Хойд тал*



*Зүүн тал*

Асуулт: Шинээр барьсан хувийн эзэмшлийн байшингийн план зургийг хэрхэн зурах вэ?

Хариулт: Жишээ



Иргэн ..... хувийн байшингийн план зураг